



**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 05

Өмнөдэлгэр сум

**Төлөөлөгчдийн ёс зүйн дүрмийг
батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Есдүгээр Хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Өмнөдэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн дүрмийг хавсралтаар баталсугай.

2.Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллахыг иргэдийн Хурлын Төлөөлөгчдөд үүрэг болгосугай.

3.Төлөөлөгчдийн ёс зүйн, дүрмийн биелэлтийн талаар жил бүр иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж байхыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Ёс зүйн зөвлөлийн дарга (Ц.Пүрэвдорж)-д даалгасугай.

ДАРГА 28.9 Ц.ПҮРЭВДОРЖ



D.disc /alban bichig/ ITH togtool

23260010

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны
02 дугаар сарын 30-ны өдрийн Есдүгээр
хуралдааны 05 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

1. Дүрмийн зорилго, нийтлэг үндэслэл

1.1. Дүрмийн зорилго нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлж, энэхүү дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг сахиж, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө биелүүлэх, иргэд сонгогчдын өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгэх, хувийн ашиг сонирхлын нөлөөлөл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төр, олон нийтийн итгэлцлийг бэхжүүлэхэд оршино.

1.2. Ёс зүйн дүрмийн заалт бүрт Төлөөлөгч саналаа өгөх бөгөөд олонхийн саналаар батлагдсан дүрмийн заалтыг хэрэгжүүлж, ажиллах үүрэг хүлээнэ.

1.3. Төлөөлөгч нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Төрийн албаны тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлыгн тухай, Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай, Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авилгын тухай, Нийтийн сонсголын тухай, Зөрчлийн тухай, Захиргааны ерөнхий хууль зэрэг хуулиудыг судалж, мөрдөж ажиллах нь ёс зүйн аливаа алдаа дутагдал, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх үндэслэл болно.

1.4. Төлөөлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн хуулийг дээдлэх, аливаа асуудалд шударга хандах, бусдын нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмыг удирдлага болгон ажиллана.

2. Төлөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээ

2.1. Төлөөлөгч нь үйл ажиллагаандаа дор дурьдсан ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллана.

2.1.1. Сонгуулийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хууль дээдэлж ажиллана.

2.1.2. Хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

2.1.3. Хүний нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэнэ.

2.1.4. Сонгогч иргэддээ чин сэтгэлээсээ үйлчилж тэдний гаргасан санал гомдол, хүсэлт дүгнэлтийн мөрөөр ажил зохион холбогдох албан тушаалтанд уламжилж, хариу авч иргэддээ мэдээлж ажиллана.

2.1.5. Хүүхдийн эрхэд байнга анхаарч, тэдний эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлж гэр бүл, хүүхдийн эрхийг хамгаалж, хүчирхийллийн эсрэг тууштай зогсоно.

2.1.6. Жендерийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт үзүүлэхээс ангид байна.

2.1.7. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан, Зөвлөл, Хорооны хуралд хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд ирц бүрэн, идэвхтэй оролцож, хэлэлцэж байгаа асуудлаар асуулт тавьж, горимын санал гаргаж хуралдааны дэгээ мөрдөж шийдвэрийг ажил хэрэгчээр батлахын дээр шалтгаангүйгээр хурал таслах, хурал хаях, хурлаа зогсоохыг шаардах, хувийн явцуу үзэл бодлоо тулгахгүй байна.

2.1.8. Гаргасан хамтын шийдвэрийг иргэд, сонгогчдод байнга таниулж санал бодлыг нь уламжилж шийдвэрийн биелэлтээр хяналт шинжилгээ хийж холбогдох шатны хурлаар хэлэлцүүлэхээр санал санаачилга гаргана.

2.1.9. Ядуурал, ажилгүйдлийг дэс дараатай бууруулах, нийгмийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн хүмүүсийн ажил амьдралд анхаарч туслах,

байгаль цаг уур болон болзошгүй аюулаар хохирсон иргэдийн сэтгэл санааг дэмжих зэргээр нийгмийн сайн үйлс, соён гэгээрүүлэх ажлыг өрнүүлж ажиллана.

2.1.10. Хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн чиглэлээр өөрийгөө чанартай бэлтгэж холбогдох хууль тогтоомж судлах, мэргэжлийн хүмүүстэй уулзаж ярилцах, иргэдийнхээ санал бодлыг тандах, холбогдох ном, гарын авлага уншиж судлах замаар хуралдаа ажил хэрэгч, мэдлэгтэй идэвхтэй оролцоно.

2.1.11. Албан болон сонгуульт үүргээ гүйцэтгэхдээ гадаад дотоодын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, үгсэн тохирох, тэднээс бэлэг шан харамж, хөнгөлттэй үйлчилгээ, зээл авах ах дүү, хамаатнаа тендерт ялуулахыг оролдох зэргээр ашиг сонирхол нь хөндөгдөхөөс байнга сэргийлж ажиллана.

2.1.12. Иргэд сонгогчидтой харилцахдаа үндэс угсаа, нас хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, улс төрийн намын харьяалал шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан хандахгүй эрх тэгш харилцаж үйлчилнэ.

2.1.13. Төлөөлөгч нь тухайн нутаг дэвсгэрийнхээ бүх иргэдийг нэр төртэй төлөөлж орон нутгаа хөгжүүлэх, хүн арддаа ажил үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх, хүний сайн сайханы төлөө санаж сэдэж, зүтгэж тэмүүлж манлайлж ажиллана.

2.1.14. Сонгуульт болон албаны аливаа ажилд хөнгөн гоомой хандах, үл тоомсорлох, биеэ тоох, цахимаар бусдыг гүтгэж, нэр төрд нь халдах, хүнд суртал чирэгдэл гаргахгүй байна.

2.1.15. Архидан согтуурах, худал хуурмаг амлалт өгөх, бусдыг хууль бусаар турхирах, худлаа хэлэх зэрэг ёс зүйн алдаа гаргахгүй байна.

2.1.16. Төлөөлөгч өөрийн ба гэр бүлийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг, орлого зарлагад гарсан их хэмжээний өөрчлөлтөө цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж тайлбарлаж байна.

2.1.17. Төлөөлөгч өөртэй нь буюу гэр бүл, хамаатан садны ашиг сонирхолтой нь холбоотой асуудал хэлэлцэх хуралдаанд өөрийн саналаараа оролцохгүй байхаа илэрхийлнэ.

2.1.18. Байгууллага хамт олны болон аль нэг албан тушаалтан, иргэний нэр төр, нууцыг хамгаалж, хилсээр гүтгэхгүй байна.

2.1.19. Төлөөлөгч үүргээ гүйцэтгэхдээ төрийн байгууллага, нутгийн захиргааны болон төрийн үйлчилгээний ажилтнуудаас албан ажлын хүрээнд зөвхөн хуулийн дагуу зөвлөмж дэмжлэг авна.

2.1.20. Хурлын шийдвэрээр тогтоосон дэг журмаа сахин биелүүлэхийн хамт хууль зөрчсөн, байгаль орчноо хамгаалах, газрын баялаг, ашигт малтмалын зөвшөөрөл олгох, орон нутгийн сангийн хөрөнгийг зарцуулах асуудалд шударга бус хандах явдалтай эвлэрдэггүй байна.

2.1.21. Тухайн шатны Засаг дарга, нутгийн захиргааны албан тушаалтанд хувийн эрх ашгийн үүднээс шахалт дарамт үзүүлэх, ашиг сонирхлоо тулгаж илэрхийлэх зэрэг хууль бус шаардлага тавихгүй байна.

2.1.22. Иргэний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж нутаг дэвсгэрийн хэмжээний ажил үйлчилгээг сайжруулах, дутагдал доголдлыг арилгуулах, хурлын шийдвэрийг биелүүлэх талаар Засаг дарга түүний орлогч, нутгийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалтанд шаардлага, асуулга тавьж, хариу авч иргэддээ мэдээлнэ.

2.1.23. Бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүлээн авсан нууцад хамаарах аливаа мэдээлэл, бичиг баримттай танилцахдаа нууцын талаархи хууль тогтоомжийг баримталж ажиллана.

2.1.24. Эрх үүргийн хүрээнд хянан шалгаж байгаа байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан журмаас гадуур хувийн хэрэгцээнд бэлэн мөнгө болон мөнгөөр үнэлэгдэх үнэт зүйлс авахыг хориглоно.

3. Төлөөлөгчийн ёс зүйн зөвлөл

1.1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ёс зүйн зөвлөлийг сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурлын даргыг оролцуулан Хурлын Төлөөлөгчөөр хамгийн олон удаа сонгогдсон 3 хүртэл Төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулна.

1.2. Ёс зүйн зөвлөл ажиллахдаа энэхүү дүрмээр тогтоосон хэм хэмжээний хүрээнд хянах, сахиулах, нийтэд мэдээлэх, зөрчлийг арилгуулах, санал дүгнэлт гаргах чиглэлийг удирдлага болгоно.

1.3. Ёс зүйн зөвлөл нь дүрмийн хэрэгжилтийг хангуулахын хамт Төлөөлөгчийн алдар хүнд, нэр төрийг хамгаалж ажиллах, худал, хилс гүтгэлэгт өртсөн бол үнэн зөв мэдээллийг өөрөөс авч мэдээлж ажиллана.

1.4. Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн асуудлаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, дүгнэлт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд гарсан асуудлыг нэг бүрчлэн шалган тогтооно.

1.5. Захиргааны ерөнхий хуулийн 25 дугаар зүйлийн дагуу асуудлыг хэлэлцэхийн өмнө уг асуудлаар судалгаа хийх, нотлох баримтуудыг цуглуулах, талуудын санал гомдлыг нэгтгэнэ.

1.6. Төлөөлөгчийн талаар гарсан санал гомдол, шүүмжлэлийг үндэслэлтэй гэж үзэх баримт нотолгоо бүрдсэн нөхцөлд уг Төлөөлөгчийн санал бодлыг сонсоно.

1.7. Ёс зүйн зөвлөл тухайн асуудлаар зөвлөмж гаргана. Зөвлөмж нь Захиргааны ерөнхий хуулийн 40 дугаар зүйлд заасан шаардлагуудтай нийцсэн байна.

1.8. Төлөөлөгч ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн нь нотлогдсон бол ёс зүйн зөвлөл доор дурдсан хариуцлага тооцохоор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулна.

1.8.1. Уучлал гуйлгах

1.8.2. Сануулах

1.8.3. Шүүхийн шийдвэрээр захиргааны хариуцлага хүлээлгэсэн бол тухайн асуудлаар хуралдаанд үг хэлэхийг тодорхой хугацаагаар хасах

1.8.4. Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн бол Төлөөлөгчөөс огцруулах

1.8.5. Зөрчил дутагдлыг дахин давтан гаргасан бол дараагийн сонгуульд нэрийг нь дэвшүүлэхээс татгалзах саналыг сонгогдсон тойргийн иргэд, сонгогч, улс төрийн намуудад мэдэгдэх

1.9. Зөвлөл уг асуудлыг хэлэлцэж шийдэхдээ олонхийн саналд тулгуурлан хууль дээдэлсэн, үнэнч шударга, хариуцлагатай ажиллах зарчмыг баримтлана.

1.10. Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг биелүүлэх, ёс зүй, түүний хэм хэмжээ, хэрэгжүүлэх арга замын талаар сургалт, семинар, хэлэлцүүлгийг хуралдааны өмнө жил бүр хийж байна.

4. Бусад

4.1. Ёс зүйн хэм хэмжээ гэдэг нь бүрэн эрхээ хэрэгжүүлэн, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний байгууллага, иргэд, сонгогчид хамт олны хүрээнд дагаж мөрдвөл зохих хэм хэмжээ, зан үйлийн нийлбэр цогц бөгөөд Төлөөлөгчийн ёс зүйн дүрмээр заасан хэм хэмжээг санаатай буюу санамсаргүй зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн дүрмээ зөрчсөн гэж үзнэ.

4.2. Хууль болон энэхүү дүрэмд заасан эрх үүргээ зориуд буюу байнга биелүүлж гүйцэтгээгүй бол эс үйлдэхгүй гэнэ. Сонгуульт үүрэг, эрх мэдлээ урвуулан ашиглах, хэтрүүлэн хэрэглэх, хурлын үйл ажиллагаа, сонгогч иргэдтэйгээ тогтмол оролцож харилцаагүй санаатайгаар зайлсхийсэн бол зөрчсөн үйлдэл гэж ойлгоно.

4.3. Их хэмжээний орлого зарлагын өөрчлөлт гэж сарын үндсэн цалин буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хуульд заасан хэмжээгээр нэмэгдүүлснийг авч үзнэ.

4.4. Ёс зүйн дүрмийн хэм хэмжээг зөрчиж, алдаа гаргаснаа Төлөөлөгч өөрөө ойлгон ухамсарлаж, нийт иргэд, Төлөөлөгчдийн өмнө уучлалт гуйсан бол Хурлын тэмдэглэлд тэмдэглэж нийтэд мэдээлнэ.